



# МОНГОЛ УЛСЫН БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ ШИНЭ ЗАХ ЗЭЭЛ, ШИНЭ БОЛОМЖ



2022 он | Санхүүгийн Зохицуулах Хороо

# Агуулга

- 01 Биржийн бус зах зээлийн үндсэн чиг үүрэг**
  - Компанийн бондын зах зээлийн ач холбогдол
  - Хувьцаа болон бондын зах зээлийн харьцуулалт
- 02 Дотоодын компанийн бондын зах зээлийн бүтэц**
  - Дотоодын компанийн бондын зохицуулалт
  - Хоёрдогч зах зээлийн арилжааны журам
  - Хөрөнгө оруулагчид (мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь)
- 03 Биржийн бус зах зээлийн эрх зүйн орчин ба шинэчлэл**
  - “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”
  - “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”
- 04 Харилцагчийг таньж мэдэх (КҮС) болон санхүүгийн гүйлгээ**
  - Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах орчин
  - КҮС ажиллагааны гурван тулгуур
- 05 Зээлжих зэрэглэл тогтоох байгууллага (ЗЗТБ)-ын үүрэг**
  - ЗЗТБ-ын суурь ойлголтууд
  - ЗЗТБ-ын хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл
  - Зээлжих зэрэглэлтэй холбоотой хязгаарлалтууд

## 01

## Компанийн бондын зах зээлийн ач холбогдол

Компанийн бондын зах зээл нь компаниудыг зээл олгогч (хөрөнгө оруулагч)-той шууд холбодог санхүүжилтийн гол сувгуудын нэг юм.



### Хөрөнгө оруулалтын санхүүжилт татах бололцоо

Банкны зээлээс гадна хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг татах боломжийг компаниудад олгодог.



### Санхүүгийн тогтвортой байдлыг хангах

Эдийн засгийн сэргэлт, өсөлтийг дэмжихээс гадна банкны системд доголдол, эрсдэл үүссэн үед бондын зах зээл нь санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг үзүүлдэг.



### Банкны систем дэх ачааллыг бууруулах

Үр ашигтай Бондын зах зээл нь олон тооны хөрөнгө оруулагчдыг татан, эрсдэлийг тараан байршуулах замаар банкны систем дэх эрсдэлийг бууруулдаг.



### Санхүүжилтын нэмэлт эх үүсвэр

Бондын зах зээл нь банкуудад нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийн гарцыг нэмэгдүүлж, улмаар урт хугацаат санхүүжилт /компанийн бонд/-ийг татах замаар урт хугацаат зээлийн эх үүсвэрийг хангах бололцоог бүрдүүлдэг.



### Банкны зээлийн үнийн тооцооллыг сайжруулах

Бондын үнэ нь зах зээл дээрх олон тооны хөрөнгө оруулагчдын үр дүнд тогтдог. Банкны зээлийг орлох боломжтой тул бондын зах зээл нь банкны зээлийн үнийн тооцооллын үр ашиггүй байдлыг бууруулж, улмаар сайжруулахад чухал нөлөө үзүүлдэг.

## 01

## Бондын зах зээл VS Хувьцааны зах зээл

### Бондын зах зээл

Хөрөнгө оруулагчдын тоо олон байх шаардлагагүй

Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зохицуулалтыг сулруулж болно

Ихэнхдээ хоёр талын хооронд, эсхүл хаалттай хүрээнд цөөн хөрөнгө оруулагчдад санал болгодог

Бонд нь ихэвчлэн олон төрөлтэй байдаг;  
Худалдан авагчийг худалдагчтай холбоход хүндрэлтэй байдаг бөгөөд хувьцааг шилжүүлэхэд ашиглагддаг аргачлалыг бондын зах зээлд шууд ашиглахад хязгаарлагдмал байдаг.

### Хувьцааны зах зээл


Хөрөнгө оруулагчдын тоо олон байх шаардлагатай

Жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай

Хувьцааг олон нийтэд болон хаалттай хүрээнд санал болгодог

Нэгж хувьцаа бүрийн үнэ, саналын эрх нь ижил байдаг;  
Хувьцааг үр ашигтайгаар арилжаалах боломжтой

# 02



Одоогоор жижиг хөрөнгө оруулагчид бондын зах зээлийн хагасыг бүрдүүлж байгаа бол цаашид мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх чиг хандлагатай байна.

## Хөрөнгө оруулагчдын төрөл

Монгол Улсад хөрөнгө оруулагчдын төрөл бондын төрлөөс хамааран харилцан адилгүй байдаг. Компанийн бондын хувьд хамгийн том хөрөнгө оруулагчид нь дотоодын өндөр орлоготой иргэд (high-net-worth-individuals, HNWIs) байна.

# 02

## Дотоодын компанийн бондын зохицуулалт

Компанийн бонд гэдэг нь олон нийтэд болон хаалттай хүрээнд санал болгодог өрийн хэрэгсэл бөгөөд холбогдох зохицуулалтад дараах зүйлс орно:

### Нээлттэй бонд “олон нийт”

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Компанийн тухай хууль
- “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”
- Биржийн бүртгэлийн болон арилжааны журам

### Хаалттай бонд “мэргэжлийн хөрөнгө оруулагч”

- “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”
  - Тодорхой өрийн хэрэгсэл, үнэт цаасыг биржийн бус зах зээл дээр хаалттай хүрээнд арилжаалах боломжтой
  - Үнэт цаасыг МҮЦАЭХ-нд бүртгүүлж, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хадгалуулах шаардлагатай
  - Шалгуур хангасан өндөр орлоготой иргэд биржийн бус зах зээлд оролцоно.

(Тайлбар) Олон нийтэд санал болгож буй компанийн бондын бүртгэлийн үйл явц



## 03

## Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам

### Үүрэг & Хариуцлага

“Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-аар Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (МҮЦАЭХ)-ны эрх, үүргийг тус тус тодорхойлж өгсөн.



#### Санхүүгийн зохицуулах хороо

СЗХ нь биржийн бус зах зээлийн дүрэм, журам болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй.

- Холбооноос ирүүлсэн биржийн бус зах зээлийн дүрэм, журмыг батламжлах
- Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон нөхцөл байдал тогтоогдсон бол арилжааг зогсоох
- Холбогдох дүрэм журам зөрчсөн этгээдүүдэд хариуцлага тооцох, арилжаанд оролцох эрхийг нь түдгэлзүүлэх



#### Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

МҮЦАЭХ нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн дагаж мөрдөх нийтлэг журам болон ёс зүйн дүрмийг тогтоох, мөрдүүлэх үндсэн зорилготой байгууллага юм.

<b>Хяналт</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэт цаасны арилжаа зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих</li> <li>• Бүртгэл болон арилжаатай холбоотой ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх</li> </ul>
<b>Ил тод байдал</b>	• Биржийн бус зах зээл дээрх арилжааны ил тод байдал, үнэт цаас гаргасан компаниудын талаарх мэдээллийг нээлттэй болгох
<b>Үйл ажиллагаа</b>	• Үнэт цаасны бүртгэл
<b>Мөнгө угаахтай тэмцэх</b>	• Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

## 03

## Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам

Энэ журмаар компанийн өрийн хэрэгслийг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, нийтэд санал болгон гаргах бондыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх, бонд гаргагч, зохицуулалттай этгээд, Хорооны эрх, үүрэг болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулсан.

*СЗХ-ны журмын дагуу биржийн бус зах зээл дээр арилжаалагдах боломжтой үнэт цаасны төрлүүд*



Өмнө нь олон нийтэд санал болгох хэлбэрээр гаргасан үнэт цаасыг нэмж гаргахдаа хаалттай хүрээнд гаргах тохиолдолд СЗХ-нд бүртгүүлэх шаардлагатай.



Хэрэв өмнө нь үнэт цаасаа олон нийтэд санал болгох хэлбэрээр гаргаж байсан хуулийн этгээд хаалттай хүрээнд өөр төрлийн үнэт цаас гаргах гэж байгаа тохиолдолд тухайн үнэт цаасыг СЗХ-нд бүртгүүлэх шаардлагатай.

*Бонд нь СЗХ-нд бүртгэлтэй байгаа хуулийн этгээд болон нээлттэй ХК-ний хаалттай хүрээнд шинээр гаргах бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:*

- Албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл
- Бонд гаргагчийн хаалттай хүрээнд бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр
- (Гуравдагч этгээд барьцаа, баталгаа гаргасан тохиолдолд) барьцаа, баталгаа, батлан даалттай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр, бонд гаргагчтай байгуулсан гэрээ
- Биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай мэргэжлийн холбооны шийдвэр
- Зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт

## 03

**Биржийн бус зах зээлд оролцогчид**

Мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдээс гадна дараах этгээд биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох боломжтой:

**Монгол Улсын иргэн**

Сүүлийн 1 жилийн сарын дундаж орлого нь 10 сая төгрөгтэй тэнцүү болон их, эсвэл 500 сая төгрөгөөс дээш цэвэр хөрөнгөтэй, сүүлийн 1 жилийн турш гадаад болон дотоодын зах зээлд үнэт цаасны арилжаа хийж байсан туршлагатай Монгол улсын иргэд.

**Төрийн байгууллага**

Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагууд, Төв банк, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Засгийн газрын тусгай сан, Зээлийн батлан даалтын сан, бүх төрлийн даатгалын сангууд

**Хуулийн этгээд**

2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 1 тэрбум төгрөгөөс доошгүй өөрийн хөрөнгөтэй хуулийн этгээд

**Бусад**

Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд

## 04

**Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нь****Харилцагчийг таньж мэдэх  
(Know Your Customer)**

Харилцагчийг таньж мэдэх (KYC) гэх ойлголт нь данс нээх, хөтлөх гэх мэт харилцагчидтай харилцдаг үнэт цаас/бондын салбарын оролцогч этгээдэд зориулсан ёс зүйн шаардлага юм.


KYC-ийн дүрмүүд нь зохицуулалттай байгууллагуудыг тухайн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн нь харилцагчиддаа тохирох эсэхийг тодорхойлохыг шаарддаг ба хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтын зөвлөхүүдийн аль алиных нь эрх ашгийг хамгаалах чухал үүргийг гүйцэтгэдэг.

Энэ нь ялангуяа биржийн зах зээлтэй харьцуулахад зохицуулалт багатай, ил тод биш, хөрвөх чадвар багатай, арилжааны болон харилцагчийн эрсдэл өндөр биржийн бус зах зээлийн хувьд чухал ач холбогдолтой юм.

KYC нь хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтын зөвлөх/брокер дилерүүдийн бүгдийнх нь эрх ашгийг хамгаалдаг. Хөрөнгө оруулагчдыг брокер дилерүүд нь тэдгээрийн эрсдэл даах чадвар, хувийн нөхцөл байдал ямар хөрөнгө оруулалт хамгийн сайн тохирч байгааг мэддэг байх замаар хамгаалдаг, харин брокер, дилерүүд үйлчлүүлэгчийнхээ багцад юу оруулах, мөн оруулах боломжгүй гэдгийг мэдсэнээр өөрсдийгөө хамгаалдаг.

# 04

## КҮС ажиллагааны гурван тулгуур



# 05

## Зээлжих зэрэглэл тогтоох байгууллага (ЗЗТБ)-ын үндсэн ойлголтууд

ЗЗТБ нь урьдчилан тодорхойлсон онооны системийг ашиглан байгууллагын өр зээлээ төлөх чадвар болон тухайн өр зээлийг үнэлсэн зээлжих зэрэглэлийн үнэлгээг гаргадаг.

\*ЗЗТБ нь мэдээллийн тэгш бус байдлыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд өөр өөр үнэт цаас гаргагчдын гаргасан бондын шинжилгээнд тогтсон нэг стандартыг ашиглах замаар хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалж байдаг.

### шинжилгээ

ЗЗТБ нь үнэт цаас гаргагч эсвэл зээлдүүлэгчид тулгарч буй эрсдэлийг илүү сайн ойлгохын тулд байгууллага, зах зээл, эдийн засгийн нөхцөл байдлын талаарх боломжтой мэдээллийг задлан шинжилж, үнэлдэг

### хөгжил

ЗЗТБ-ын үнэлгээ нь мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмэр оруулдаг.

### хэрэглээ

Үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, зах зээлийн бусад оролцогчид, санхүүгийн хяналт шалгалт хийдэг байгууллагууд эдгээр үнэлгээг хөрөнгө оруулалтын эрсдэл болон тодорхой бус байдлыг ойлгох, эрсдэлийг бууруулах, мөн үнэт цаас гаргагчийн өртгийг бууруулахад ашигладаг.

### нөлөө

ЗЗТБ-ын зээлжих зэрэглэлийн үнэлгээ нь үнэт цаас гаргагчдын хөрөнгө оруулалт татах боломж, шийдвэр гаргалт, санхүүгийн гүйлгээний бүтцэд нөлөөлдөг.



# 05

## ЗЗТБ-ын хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл

### ЗЗТБ-ын үйл ажиллагааны зарчмууд

“Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-аар Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (МУЦАЭХ)-ны эрх, үүргийг тус тус тодорхойлж өгсөн.

1

ЗЗТБ нь зээлдэгч, зээлдүүлэгч болон бусад зах зээлд оролцогчдын мэдээллийн тэгш бус байдлыг бууруулахад туслах дүгнэлтийг гаргах шаардлагатай.

2

Үнэлгээний шийдвэр нь бие даасан, улс төр, эдийн засгийн дарамт, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагатай.

3

Ил тод, нээлттэй байх нь ЗЗТБ-ын үйл ажиллагааны нэг зорилго байх шаардлагатай.

4

Аливаа үнэт цаас гаргагч эсвэл түүний төлөөлөгчдөөс ЗЗТБ-д дамжуулсан нээлттэй бус бүх мэдээллийг нууцлах шаардлагатай.

### \* Зээлжих зэрэглэлийн хязгаарлалтууд



Зээлжих зэрэглэл өндөр байгаа нь өрийг төлж барагдуулах баталгаа ч биш, төлбөрийн чадваргүй болох нөхцөл байдал үүсэхгүй байх баталгаа ч биш юм.



Зээлжих зэрэглэлийн өөрчлөлт нь зах зээлд оролцогчдын ойлголтод нөлөөлж болох хэдий ч энэ нь компанийн зээлийн чадвар, өр төлбөрийг тусгасан олон хүчин зүйлүүдийн зөвхөн нэг нь гэж үзэх хэрэгтэй.



Зээлжих чадварыг илэрхийлсэн зээлийн үнэлгээний тэмдэглэгээ болон хэмжигдэхүүний цаадах бодит утга, агуулгыг анхаарч ойлгох хэрэгтэй.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

---



Засгийн газрын IV байр  
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар хот, Монгол улс

 51-26 4444

 [info@frc.mn](mailto:info@frc.mn)